XXIII.1.1.103	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Сүхбаатар, Асгат сум/	2013	2014	550.0	1,014.0	464.0	84%
XXIII.1.1.104	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Сэлэнгэ, Шаамар, Дулаанхаан тосгон/	2012	2014	760.0	786.6	26.6	4%
XXIII.1.1.105	Спорт заалны барилга /Өвөрхангай, Нарийнтгэл сум/	2013	2014	500.0	840.0	340.0	68%
XXIII.1.1.106	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Говьсүмбэр, Сүмбэр, 1 дүгээр цэцэрлэг/	2013	2014	400.0	1,008.0	608.0	152%
XXIII.1.1.107	Сургуулийн барилга, 640 суудал /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2011	2014	2,300.0	3,274.0	974.0	42%
XXIII.1.1.108	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2008	2014	1,990.0	3,680.0	1,690.0	85%



XXIII.1.1.109	Дотуур байрны барилга, 100 ор /Дундговь, Өндөршил сум/	2013	2014	700.0	1,060.0	360.0	50%
XXIII.1.1.110	Дотуур байрны барилга, 120 ор /Гөв, Балсүмбэр сум/	2013	2014	750.0	1,200.0	450.0	60%
XXIII.1.1.111	Дотуур байрны барилга, 150 ор /Улаанбаатар, Сүхбаатар, 25 дугаар тусгай сургууль/	2013	2014	800.0	1,600.0	800.0	100%
XXIII.1.1.112	Спорт заалны барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 60 дугаар сургууль/	2013	2014	650.0	1,285.6	635.6	98%
XXIII.1.1.113	Сургуулийн дотуур байрны барилга /Баян-Өлгий, Улаанхус, Согор баг/	2013	2014	1,270.0	1,300.0	30.0	2%
XXIII.1.1.115	Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 3-р сургууль/	2012	2014	3,100.0	5,800.0	2,700.0	87%
XXIII.1.1.116	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 11-р сургууль/	2012	2014	1,200.0	2,100.0	900.0	75%
XXIII.1.1.117	Цэцэрлэгийн барилга, /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2012	2014	650.0	1,000.0	350.0	54%
XXIII.1.1.118	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, Лаборатори сургууль/	2012	2014	2,500.0	3,840.0	1,340.0	54%
XXIII.1.1.119	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 104-р сургууль/	2012	2014	2,400.0	3,840.0	1,440.0	60%
XXIII.1.1.120	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 7-р хороо/	2012	2014	680.0	1,100.0	420.0	62%
XXIII.1.1.121	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 8-р хороо/	2012	2014	680.0	1,100.0	420.0	62%
XXIII.1.1.122	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо/	2012	2014	680.0	1,100.0	420.0	62%
XXIII.1.1.123	Цэцэрлэгийн барилга, /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 8-р хороо/	2012	2014	425.0	1,200.0	775.0	182%
XXIII.1.1.124	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 11-р хороо/	2012	2014	425.0	1,200.0	775.0	182%
XXIII.1.1.125	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 16-р хороо/	2012	2014	425.0	1,200.0	775.0	182%

XXIII.1.1.126	Спорт заалны барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 46-р сургууль/	2013	2014	550.0	750.0	200.0	36%
XXIII.1.1.127	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дархан-Уул, Дархан/	2013	2014	800.0	1,250.0	450.0	56%
XXIII.1.1.128	Цэцэрлэгийн барилга, /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 18-р хороо/	2012	2014	425.0	1,200.0	775.0	182%
XXIII.1.1.129	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 26-р хороо/	2012	2014	680.0	1,100.0	420.0	62%
XXIII.1.1.130	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Өмнөговь, Даланзадгад/	2013	2014	700.0	1,015.0	315.0	45%
XXIII.1.1.131	Сургуулийн барилга, 320 суудал /Завхан, Отгон сум/	2010	2014	950.0	1,233.3	283.3	30%
XXIII.1.1.132	Дотуур байрны барилга, 100 ор /Дорнод, Дашбалбар сум/	2013	2014	720.0	974.9	254.9	35%
XXIII.1.1.133	Сургуулийн барилга, спорт заал, 960 суудал /Говь-Алтай, Есөнбулаг, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн харъяа анагаах ухааны коллеж	2013	2014	3,970.0	5,184.7	1,214.7	31%
XXIII.1.1.134	Сургуулийн барилга, 320 суудал /Сүхбаатар, Асгат сум/	2010	2014	880.0	1,297.0	417.0	47%
XXIII.1.1.135	Сургуулийн барилга, 928 суудал /Дорнод, Хэрлэн сум, "Хан-Уул" цогцолбор/	2011	2014	2,900.0	3,885.9	985.9	34%
XXIII.1.1.136	Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Архангай, Эрдэнэмандал сум/	2012	2015	1,800.0	4,661.7	2,861.7	159%
XXIII.1.1.137	Сургуулийн барилга, 640 суудал, /Булган, Булган сум, 1 дүгээр сургууль/	2012	2014	2,300.0	2,663.7	363.7	16%
XXIII.1.1.138	Сургуулийн барилга, 640 суудал, /Дорнод, Баян-Уул сум/	2012	2014	2,485.0	2,674.6	189.6	8%
XXIII.1.1.139	Сургуулийн дотуур байрны барилга, 150 ор /Хэнтий, Батноров сум/	2012	2014	1,141.6	1,234.1	92.5	8%
XXIII.1.1.140	Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Говь-Алтай, Хөхморьт сум/	2012	2014	650.0	1,343.9	693.9	107%
XXIII.1.1.141	Спорт заалны барилга /Улаанбаатар, Чингэлтэй сум, 61-р сургууль/	2012	2014	550.0	1,050.0	500.0	91%
XXIII.1.1.142	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баянхонгор, Гурванбулаг сум/	2012	2014	700.0	874.7	174.7	25%
XXIII.1.1.143	Цэцэрлэгийн барилга /Ховд, Мөст сум/	2012	2014	650.0	772.7	122.7	19%
XXIII.1.1.144	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Багануур дүүрэг/	2012	2014	500.0	1,097.8	597.8	120%



XXIII.1.1.145	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Хөвсгөл, Эрдэнэбулган сум/	2012	2014	500.0	868.0	368.0	74%
XXIII.1.1.146	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Хөвсгөл, Галт сум/	2012	2014	650.0	1,065.0	415.0	64%
XXIII.1.1.147	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Цагаанчулуут сум/	2012	2014	835.0	952.3	117.3	14%
XXIII.1.1.148	Дотуур байрны барилга /Хөвд, Мөст сум/	2013	2014	700.0	1,050.0	350.0	50%
XXIII.1.1.149	Цэцэрлэгийн барилга /Хэнтий, Галшар сум/	2013	2014	400.0	956.4	556.4	139%
XXIII.1.1.150	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Баян-Өлгий, Цэнгэл сум/	2013	2014	480.0	1,136.3	656.3	137%
XXIII.1.1.151	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Хөвд, Жаргалант сум/	2012	2014	358.2	710.0	351.8	98%
XXIII.1.1.152	Сургуулийн барилга, спорт заал 640 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Их залуу баг/	2011	2014	1,800.0	2,339.5	539.5	30%
XXIII.1.1.153	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Багануур дүүрэг, 3 дугаар хороо/	2013	2014	2,470.3	2,870.3	400.0	16%
XXIII.1.1.154	Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Дундговь, Сайхан-Овоо сум/	2012	2014	650.0	1,090.0	440.0	68%
XXIII.1.1.155	Спорт заалны барилга /Өмнөговь, Манлай сум/	2013	2014	350.0	750.0	400.0	114%
XXIII.2.1.2	Биологийн идэвхтэй бэлдмэлийн үйлдвэрлэл, туршилтын цех /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2012	2014	500.0	2,063.0	1,563.0	313%
<b>XXIV</b>	<b>ЗАМ ТЭЭВРИЙН САЙД</b>			<b>11,192.4</b>	<b>14,772.1</b>	<b>3,579.7</b>	
XXIV.1.1.4	Германы сэргээн босголт банкны зээлээр хэрэгжүүлэх "Нийслэл хотын хүнсний найдвартай байдлыг хангах орон нутгийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл"-ийн 78.8 км хатуу хучилттай авто зам /Төв, Борнуур, Жаргалант, Паргизан, Бэлтсүмбэр/	2010	2014	11,192.4	14,772.1	3,579.7	32%
<b>XXV</b>	<b>СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД</b>			<b>53,116.9</b>	<b>92,786.1</b>	<b>39,669.2</b>	
XXV.1.1.4	Аймгийн хөгжимт драмын театрын барилга /Архангай/	2012	2015	7,100.0	9,448.3	2,348.3	33%
XXV.1.1.9	Гандангэчлэн хийдийн өргөтгөлийн барилга, 1080 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2008	2014	12,892.0	18,354.7	5,462.7	42%
XXV.1.1.10	Совьлын төвийн барилга, 500 суудал /Завхан, Тосонцэнгэл/	2011	2014	2,200.0	3,322.8	1,122.8	51%
XXV.1.1.11	Хөгжимт жүжгийн театрын барилга, 800 суудал /Завхан/	2011	2015	3,000.0	9,968.0	6,968.0	232%



XXV.1.1.12	Хан-Хэнтий чуулгын барилга /Хэнтий, Өндөрхаан/	2011	2015	3,500.0	8,353.7	4,853.7	139%
XXV.1.1.13	Совёлын төвийн болон Захирагчийн албаны барилга /Сэлэнгэ, Орхонтуул, Рашаанг/	2012	2014	1,000.0	1,383.7	383.7	38%
XXV.1.1.14	Совёлын төвийн барилга, 250 суудал /Увс, Наранбулаг/	2012	2014	700.0	900.8	200.8	29%
XXV.1.1.15	Совёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Баянхайрхан/	2012	2014	700.0	1,076.0	376.0	54%
XXV.1.1.16	Совёлын төвийн барилга /Юрхон, Баян-Өндөр, Дэнж баг/	2012	2014	900.0	1,174.8	274.8	31%
XXV.1.1.17	Совёлын төвийн барилга /Архангай, Батцэнгэл/	2012	2014	350.0	885.0	535.0	153%
XXV.1.1.18	Алтай чуулгын барилга, 500 суудал /Говь-Алтай/	2008	2014	4,700.0	5,550.0	850.0	18%
XXV.1.1.19	Совёлын төвийн барилга /Өвөрхангай, Уянга/	2011	2014	1,300.0	1,402.3	102.3	8%
XXV.1.1.20	Соёл, урлагийн заал /Дорнод, Баянтүмэн/	2012	2014	817.0	919.3	102.3	13%
XXV.1.1.21	Совёлын төвийн барилга, 250 суудал /Сэлэнгэ, Шаамар/	2012	2014	863.9	1,081.9	218.0	25%
XXV.2.1.6	Усан бассейны барилга /Сэлэнгэ, Сүхбаатар/	2011	2014	1,000.0	4,493.8	3,493.8	349%
XXV.2.1.7	Спорт цогцолбор, 2200 суудал /Дархан-Уул/	2011	2015	11,041.0	21,443.0	10,402.0	94%
XXV.2.1.8	Спорт цогцолбор /Ховд, Манхан/	2012	2014	600.0	2,118.0	1,518.0	253%
XXV.2.1.9	Спорт заалны барилга /Дорнод, Хэрлэн, 2 дугаар баг/	2012	2014	453.0	910.0	457.0	101%
<b>XXVII</b>	<b>ҮЙЛДВЭР ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД</b>			<b>650.0</b>	<b>1,351.3</b>	<b>701.3</b>	
XXVII.1.2	Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн барилга /Улаанбаатар, Хан-Уул/	2013	2014	650.0	1,351.3	701.3	108%
<b>XXVIII</b>	<b>ХӨДӨЛМӨРИЙН САЙД</b>			<b>4,800.0</b>	<b>9,673.8</b>	<b>4,873.8</b>	
XXVIII.1.1.5	МСУТ-ийн хичээлийн байр, дадлагын байр, спорт заал, 960 суудал /Дундговь, Сайнцагаан сум/	2012	2015	3,100.0	6,738.0	3,638.0	117%
XXVIII.1.1.7	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны барилга, 200 ор /Дундговь, Сайнцагаан сум/	2012	2015	1,200.0	2,281.8	1,081.8	90%
XXVIII.1.1.8	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн биеийн тамирын заалны барилга /Өмнөговь/	2013	2014	500.0	654.0	154.0	31%
<b>XXIX</b>	<b>ХҮН АМЫН ХӨРЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД</b>			<b>4,500.0</b>	<b>8,299.9</b>	<b>3,799.9</b>	
XXIX.1.1.1	Цахим мэдээллийн төв, Тонгог төхөөрөмжийн хамт /Нийгмийн даатгалын сангийн эх үүсвэрээр баригдах цахим архивтай хамтатган цогцор шийдвэрлэх/ /Улаанбаатар/	2012	2014	2,500.0	3,299.9	799.9	32%



XXIX.2.1.1	Усан спорт цогцолбор, 1000 хүн /Улаанбаатар, Найрамдал зуслан/	2013	2015	2,000.0	5,000.0	3,000.0	150%
<b>XXXI</b>	<b>ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД</b>			<b>74,787.1</b>	<b>119,573.8</b>	<b>44,786.7</b>	
XXXI.1.1	Төрөх эмнэлэг, 300 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2010	2014	19,000.0	32,222.8	13,222.8	70%
XXXI.1.2	Улсын клиникийн 1 дүгээр нэгдсэн эмнэлгийн өргөтгөл /Улаанбаатар/	2011	2015	13,780.0	15,549.1	1,769.1	13%
XXXI.1.3	Эрүүл мэндийн төвийн барилга, 100 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2010	2014	5,432.4	7,700.0	2,267.6	42%
XXXI.1.4	Геронтологийн төв, 60 ор /Улаанбаатар/	2011	2014	4,724.6	7,392.9	2,668.3	56%
XXXI.1.5	Төрөх эмнэлэг, 50 ор /Булган, Булган/	2011	2014	1,600.0	2,144.3	544.3	34%
XXXI.1.6	Төрөх эмнэлэг, 50 ор /Завхан, Улиастай/	2011	2014	2,179.2	2,390.0	210.8	10%
XXXI.1.7	Төрөх эмнэлэг, 50 ор /Дорноговь, Сайншанд/	2011	2014	1,817.9	2,093.0	275.1	15%
XXXI.1.8	Эмнэлгийн барилга, 15 ор /Төв, Борнуур/	2012	2014	773.6	1,084.6	311.0	40%
XXXI.1.9	Эмнэлгийн барилга, 15 ор /Өвөрхангай, Нарийнтээл/	2012	2014	541.8	774.5	232.7	43%
XXXI.1.13	Эрүүл мэндийг дэмжих төв /Баян-Өлгий/	2012	2014	700.0	779.0	79.0	11%
XXXI.1.14	Эмнэлгийн амбулаторийн барилга /Булган, Хулаг-Өндөр/	2012	2014	500.0	879.4	379.4	76%
XXXI.1.20	Гэмтэл, согор судлалын үндэсний төвийн харьяа тугангийн төвийн барилга /Улаанбаатар/	2013	2015	8,000.0	26,000.0	18,000.0	225%
XXXI.1.22	Сумын эрүүл мэндийн төв, 50 ор /Өмнөговь, Цогтшир/	2013	2014	5,211.8	5,419.2	207.4	4%
XXXI.1.23	Сумын эрүүл мэндийн төв, 50 ор /Өмнөговь, Ханбогд/	2013	2014	5,419.2	5,211.8	-207.4	-4%
XXXI.1.24	Говийн бүсийн эмнэлгээ, оношлогооны төвийн барилга /Өмнөговь, Далагнаадаг/	2012	2014	2,657.7	7,247.7	4,590.0	173%
XXXI.1.26	Төрөх эмнэлэг, 50 ор /Говь-Алтай, Есөнбулаг/	2013	2014	2,218.9	2,324.6	105.7	5%
XXXI.1.46	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн засвар	2013	2014	230.0	360.9	130.9	57%
<b>XXXII</b>	<b>ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД</b>			<b>9,000.0</b>	<b>24,400.0</b>	<b>15,400.0</b>	
XXXII.1.6	Чойр дэд станцыг өргөтгөх автотрансформаторын хүчин чадлыг нэмэгдүүлэх, Релей хамгаалалтын автоматын шинэчлэл	2013	2015	9,000.0	24,400.0	15,400.0	171%
	<b>НИЙТ ДҮН</b>			<b>388,660.8</b>	<b>678,639.1</b>	<b>289,976.3</b>	



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 9 дүгээр  
сарын 18-ны өдөр

Дугаар 320

Улаанбаатар  
хот

### Журам батлах тухай

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 8.7, Иргэний бүртгэлийн тухай хуулийн 23.5-ыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын дипломат, албан паспорт, буцах үнэмлэх олгох, эзэмших, хадгалах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журмыг 2013 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж ажиллахыг Гадаад харилцааны сайд Л.Болдод даалгасугай.

3. Энгийн паспорт, зорчих үнэмлэх, хил орчмын нутаг дэвсгэрт хялбарчилсан журмаар зорчих үнэмлэхний хувьд шинэчилсэн журам гартал Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 184 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ыг мөрдөж ажиллахыг Хууль зүйн сайд Х.Тэмүүжинд үүрэг болгосугай.

4. Шаардлагатай тохиолдолд Төрийн захиргааны ТЗ-4-ТЗ-5 зэрэглэлд хамаарах албан тушаалтанд, УИХ-д суудалтай улс төрийн намын удирдах зөвлөлийн гишүүдэд, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нарт, олимп, тив, дэлхийн хэмжээний олон улсын тэмцээн, уралдаанд оролцох Монгол Улсын үндэсний шигшээ багийн тамирчид, тэдгээрийн дасгалжуулагч, эмч нарт тухайн байгууллагын хүсэлтийг үндэслэн Монгол Улсын албан паспорт олгож байхыг Гадаад харилцааны сайд Л.Болдод даалгасугай.

5. Өмнө нь олгогдсон Монгол Улсын албан паспортыг хугацаа нь дуустал ашиглуулах талаар холбогдох арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд Л.Болдод даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД**

**Л.БОЛД**



Засгийн газрын 2013 оны 320 дугаар  
тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ДИПЛОМАТ, АЛБАН ПАСПОРТ, БУЦАХ  
ҮНЭМЛЭХ ОЛГОХ, ЭЗЭМШИХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын дипломат, албан паспорт, буцах үнэмлэх олгох, эзэмших, хадгалахад энэхүү журмыг баримтална.

1.2. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг баримтална.

Хоёр. Дипломат, албан паспорт

2.1. Дипломат, албан паспорт нь Монгол Улсын иргэнийг гадаад улсад зорчин явааг батлан гэрчлэх баримт бичиг мөн.

2.2. Дипломат, албан паспорт нь төрийн өмч байна.

2.3. Дипломат, албан паспорт нь Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага (ИКАО)-ын стандартад нийцсэн байх бөгөөд иргэний биеийн давхцахгүй өгөгдлийг (цээж зураг, хурууны хээ) агуулсан байна.

2.4. Дипломат, албан паспортанд ургийн овог, эцэг (эх)-ийн нэр, нэр болон регистрийн дугаарын өмнөх үсгийн латин галигийн бичилтийг иргэний үнэмлэх болон иргэний бүртгэл хариуцсан төрийн захиргааны байгууллагын тогтоосон стандартыг баримтлан бичнэ.

Гурав. Дипломат, албан паспортыг эзэмших, хүчинтэй байх  
хугацааны тухай

3.1. Дипломат, албан паспортыг энэхүү журмын 5-д заасан Монгол Улсын иргэнд олгоно.

3.2. Дипломат, албан паспорт нь 5 хүртэл жилийн хугацаанд дэлхийн бүх улсад зорчиход хүчинтэй байх бөгөөд паспортанд дахин сунгалт хийгдэхгүй.

3.3. Монгол Улсын иргэн хоёр хүртлэх дипломат, албан паспортыг зэрэг эзэмшиж болно. Хоёр дахь паспортыг холбогдох байгууллагын албан



ёсны хүсэлтийг үндэслэн гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр олгоно.

Дөрөв. Дипломат, албан паспорт олгох байгууллага

4.1. Дипломат, албан паспорт олгох, хүчингүй болгох ажлыг гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

4.2. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дипломат паспортанд, гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын Консулын газрын захирал албан паспортанд, тэдгээрийн эзгүйд орлох эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.

4.3. Дипломат, албан паспортыг мэдүүлэг хүлээн авснаас хойш ажлын 4 өдөрт багтаан олгоно.

Тав. Дипломат, албан паспорт эзэмшигч

5.1. Дипломат паспортыг дор дурдсан албан тушаалтан эзэмшинэ:

5.1.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, тэдгээрийн гэр бүлийн гишүүд;

5.1.2. төрийн өндөр албан тушаалын ТӨ-III-ТӨ-IV, ТӨ-IVА зэрэглэлд хамаарах албан тушаалтан, түүний эхнэр буюу нөхөр;

5.1.3. төрийн өндөр албан тушаалын ТӨ-V-ТӨ-VI, ТӨ-VА-ТӨ-VIA зэрэглэлд хамаарах албан тушаалтан, түүний эхнэр буюу нөхөр;

5.1.4. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд асан хүмүүс болон тэдгээрийн гэр бүлийн гишүүд төрийн тусгай хамгаалалтад байх хугацаанд;

5.1.5. Гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дипломат албан тушаалтан;

5.1.6. ТЗ-14, АА-I, ТҮ-14 зэрэглэлийн албан тушаалтан;

5.1.7. ТТ-18 зэрэглэлийн албан тушаалтан;



5.1.8. Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын дипломат албан тушаалтан болон тэдгээрийн эхнэр буюу нөхөр, 18 хүртэл насны хүүхэд;

5.1.9. Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд болон Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин дипломат цолтой хүн, түүний эхнэр буюу нөхөр;

5.1.10. төр, засгийн тэргүүн нар гадаадад зорчиход дагалдан явах хамгаалалтын албаны ажилтан.

5.2. Албан паспортыг дор дурдсан албан тушаалтан болон тэдгээртэй адилтгах албан тушаал хашиж буй иргэн эзэмшинэ:

5.2.1. төрийн албан тушаалын АА-2-АА-11 зэрэглэлд хамаарах албан тушаалтан<sup>1</sup>;

5.2.2. төрийн захиргааны ТЗ-6-ТЗ-13 зэрэглэлд хамаарах албан тушаалтан;

5.2.3. төрийн үйлчилгээний ТҮ-11-13 зэрэглэлд хамаарах албан тушаалтан;

5.2.4. төр, засгийн тэргүүн нар гадаадад зорчиход дагалдан явах эмч болон бусад үйлчилгээний ажилтан;

5.2.5. харьяа төрийн байгууллагын тодорхойлолтын дагуу төрийн тусгай албаны ангилал, зэрэглэлд хамаарах албан тушаалтан;

5.2.6. батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлолтыг үндэслэн Монгол Улсын олон улсын гэрээ, тохиролцооны дагуу гадаад оронд энхийг сахиулах үүрэг гүйцэтгэх албан хаагчид;

5.2.7. хилийн чанад дахь Засгийн газар хоорондын олон улсын байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаал хашиж буй Монгол Улсын иргэн, түүний эхнэр буюу нөхөр, 18 хүртэл насны хүүхэд;

5.2.8. Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын үйлчилгээ, техникийн ажилтан, тэдний эхнэр буюу нөхөр, 18 хүртэл насны хүүхэд.

<sup>1</sup>УИХ-ын 2009 оны 6 дугаар тогтоол.



5.3. Сумын болон дүүргийн Засаг дарга;

5.4. Улсын Их Хурлын гишүүний орон тооны зөвлөх болон туслах;

5.5. Засгийн газрын гишүүний орон тооны зөвлөх болон туслах;

5.6. Монгол Улсын Өргөмжит консулаар томилогдон ажиллаж буй Монгол Улсын иргэн;

5.7. Дипломат цолтой ахмад ажилтнууд, тэдгээрийн эхнэр буюу нөхөр;

5.8. Онцгой тохиолдолд гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийг үндэслэн Монгол Улсын иргэнд дипломат, албан паспорт олгож болно.

Зургаа. Дипломат, албан паспорт олгох үндэслэл

6.1. Дипломат, албан паспорт мэдүүлэхэд дор дурдсан материалыг бүрдүүлнэ:

6.1.1. дипломат, албан паспорт мэдүүлэх хуудас;

6.1.2. тухайн албан тушаалтанд дипломат эсхүл албан паспорт олгохыг хүссэн төрийн байгууллагын албан бичиг;

6.1.3. тухайн ажилтныг хашиж буй албан тушаалд нь томилсон буюу сонгосон төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрийн хуулбар;

6.1.4. иргэний үнэмлэхийн хуулбар;

6.1.5. эхнэр, нөхөр, хүүхэд, гэр бүлийн гишүүд дипломат, албан паспорт мэдүүлэх бол гэрлэлтийн гэрчилгээний хуулбар, төрсний гэрчилгээний хуулбар, гэр бүлийн гишүүнийг нотлох баримт зэргийг нэмж бүрдүүлнэ;

6.1.6. шаардлагатай тохиолдолд гадаадад зорчихыг түдгэлзүүлэх үндэслэл байхгүйг нотолсон баримт нэмж бүрдүүлнэ<sup>2</sup>;

<sup>2</sup>Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах хуулийн 5 дугаар зүйлийн 1-д дурдсан үндэслэл байхгүйг нотлох баримт;



#### 6.1.7. төлбөр төлсөн баримт.

6.2. Хилийн чанадад түр болон удаан хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэн дипломат, албан паспорт мэдүүлэхдээ энэхүү журмын 6.1.1-6.1.7-д заасан баримт бичгийг бүрдүүлж гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлж болно.

6.3. Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан дипломат, албан паспорт мэдүүлж буй иргэн холбогдох шуудангийн зардлыг өөрөө хариуцна.

6.4. Тухайн албан тушаалтны бүрэн эрх дуусахаас 6 сарын өмнөх хугацаанд түүнд дипломат, албан паспорт шинээр олгохыг хориглоно.

6.5. Гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох хууль тогтоомжийг үндэслэн дипломат, албан паспорт олгохоос татгалзах эрхтэй байна.

#### Долоо. Дипломат, албан паспорт хадгалах

7.1. Төрийн байгууллагын төрийн захиргааны удирдлагын газар, Тамгын газар, хэлтэс эсхүл гадаад харилцаа хариуцсан нэгж, ДТГ-ын тэргүүн тухайн байгууллагынхаа албан тушаалтнуудын дипломат, албан паспортыг мэдүүлэх, сунгуулах асуудлыг хариуцаж, дипломат, албан паспортыг гадаадад зорчиход нь олгож, буцаж ирмэгц эгүүлэн авч, хадгалах, тухайн албан тушаалтан халагдах, чөлөөлөгдөх эсхүл паспортын хугацаа дуусахад нь Гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын Консулын газарт илгээж, хүчингүй болгуулах үүрэг хүлээнэ. Мөн эдгээр газар, нэгж нь тухайн жилийн 12 дугаар сарын 25-ны байдлаар өөрийн байгууллагын ажилтнуудын дипломат, албан паспорт олголт, сунгалт, хадгалалт болон байгууллагын орон тоо, бүтцэд гарсан өөрчлөлтийн талаар тайлан гаргаж, гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын Консулын газарт ирүүлнэ. Хүчингүй болсон дипломат, албан паспортыг эзэмшигч хүсвэл өөрт нь дурсгал болгон үлдээж болно.

7.2. Дипломат, албан паспорт эзэмшигч нь тухайн паспортыг үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу захиргааны хариуцлага хүлээнэ. Дипломат, албан паспорт мэдүүлэхдээ хуурамч баримт бичиг бүрдүүлэх, худал мэдээлэл өгөх, бусдад ашиглуулах, худалдах, барьцаалах, хуурамчаар үйлдэх болон бусад хууль бус үйлдэл





гаргасан этгээд, албан тушаалтан хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ<sup>3</sup>.

7.3. Хүчин төгөлдөр бус эсхүл зөрчилтэй дипломат, албан паспортыг Хилийн шалган нэвтрүүлэх боомт дээр хураан авч гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын Консулын газарт шилжүүлнэ.

7.4. Албан тушаалаас чөлөөлөгдсөн, халагдсан болон бусад шалтгаанаар дипломат, албан паспорт эзэмших эрхгүй болсон иргэн эзэмшиж буй дипломат, албан паспортаа хүчингүй болгохоос татгалзах эсхүл зайлсхийх тохиолдолд гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын Консулын газрын шийдвэрээр уг паспортыг хүчингүй болгон зарлана.

#### Найм. Буцах үнэмлэх

8.1. Үндэсний гадаад паспортыг түр орлох баримт бичгийг буцах үнэмлэх гэнэ. Гадаадад түр болон удаан хугацаагаар зорчиж байгаад паспортаа үрэгдүүлсэн, гэмтээсэн болон гадаадад төрсөн Монгол Улсын иргэн богино хугацаанд эх орондоо буцах бол Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газар буцах үнэмлэх олгоно.

8.2. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн буцах үнэмлэхийн загварыг батална.

8.3. Гадаад харилцааны асуудал хариуцсан Төрийн захиргааны төв байгууллага буцах үнэмлэхийг хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудад түгээх, зарцуулалтад хяналт тавих асуудлыг хариуцна.

8.4. Дипломат төлөөлөгчийн газрууд буцах үнэмлэх олголтын тайланг улирал бүр гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын Консулын газарт ирүүлнэ.

8.5. Буцах үнэмлэх нь олгосон өдрөөс 12 сарын хугацаанд хүчинтэй байна.

8.6. Буцах үнэмлэх олгоход дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

<sup>3</sup>Захиргааны хариуцлагын тухай хууль, Эрүүгийн хуулийн холбогдох заалтыг баримтална.



8.6.1. буцах үнэмлэх мэдүүлэх хуудас;

8.6.2. иргэний үнэмлэхийн баталгаажсан хуулбар эсхүл иргэний бүртгэл хариуцсан төрийн байгууллагын дэлгэрэнгүй лавлагаа;

8.6.3. 3.5x4.5 см-ийн хэмжээний цагаан дэвсгэртэй цээж зураг 2 хувь;

8.6.4. төлбөр төлсөн баримт;

8.6.5. шаардлагатай тохиолдолд тухайн иргэний гээгдүүлсэн гэх улсын хил нэвтрэх эрхийн баримт, Монгол Улсын хил нэвтэрсэн лавлагаа.

8.7. Буцах үнэмлэх авах иргэн өндөр настан, эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа, түр саатуулагдсан, насанд хүрээгүй, бусад хүндэтгэн үзэх шалтгаантай бол эмнэлгийн байгууллагын албан ёсны дүгнэлт, хорих байгууллага, цагаачлалын алба, түр саатуулах байгууллагын тодорхойлолт, насанд хүрээгүй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчийн хүсэлт зэргийг үндэслэн итгэмжлэгдсэн хүнээр буюу баталгаат шуудангаар дамжуулан буцах үнэмлэх олгож болно.

8.8. Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар байхгүй эсхүл алслагдсан газар байгаа иргэдэд баталгаат шуудангаар дамжуулан буцах үнэмлэхийг олгож болно.

8.9. Буцах үнэмлэхийг Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, бие даасан Консулын хэлтэстэй бол Консулын хэлтсийн дарга, тэдгээрийн эзгүйд орлох дипломат ажилтан гарын үсэг зурж баталгаажуулна.

8.10. Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газар буцах үнэмлэх олголтын тайлан, бүртгэлийн дэвтрийн хамт иргэний бүртгэл хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухайн жилийн 12 дугаар сарын 25-ны байдлаар тасалбар болгон дараа жилийн 1 дүгээр сарын 5-ны өдрийн дотор гарган хүргүүлнэ.

8.11. Буцах үнэмлэхийг хилийн шалган нэвтрүүлэх боомт дээр хураан авч иргэний бүртгэл хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.



8.12. Шаардлагатай тохиолдолд буцах үнэмлэхийн бүрдүүлэлтийн материалыг цахим шуудангаар хүлээн авч болно.

Ес. Бусад

9.1. Гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дипломат, албан паспорт, буцах үнэмлэхний загварыг өөрийн орны болон гадаадын холбогдох байгууллага, албанд хүргүүлж, гарсан өөрчлөлтийн талаар цаг тухайд нь мэдэгдэх үүрэгтэй.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 9 дүгээр  
сарын 21-ний өдөр

Дугаар 325

Улаанбаатар  
хот

### **Олон улсын спортын тэмцээн, наадам зохион байгуулах тухай**

Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.5-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад олон улсын дараах тэмцээнүүдийг 2014 онд зохион байгуулсугай:

- а) “Чингис хаан-2014” жүдо бөхийн Гран-При тэмцээн;
- б) Жүдо бөхийн Зүүн Азийн аварга шалгаруулах тэмцээн;
- в) Чөлөөт бөхийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн;
- г) Дэлхийн шилдэг эмэгтэй шатарчдын Гран-При тэмцээн;
- д) Олс таталтын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн;
- е) Гандболын цомын аварга шалгаруулах олон улсын тэмцээн;
- ж) Тэшүүрийн олон улсын тэмцээн (өсвөр үе, залуучууд);
- з) “Улаанбаатар Марафон” олон улсын марафон гүйлтийн тэмцээн;
- и) “Алтаргана-2014” урлаг, спортын олон улсын наадам.



2. Дээрх тэмцээнүүдийг зохион байгуулахад шаардагдах зардлыг 2014 оны төсөвт тусган санхүүжүүлж, тамирчдын болон тэмцээний зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангах арга хэмжээ авахыг Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэлд даалгасугай.

3. Тэмцээнийг удирдлага, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулж, дүнг 2014 оны IY улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэлд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Ц.ОЮУНГЭРЭЛ**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2.25

Индекс: 14003